Так, такие личные имена как БАЖИ > БАЖИЕВЪ. БАЖУЕВЪ, конечно, сопоставимы с тувинским бызаа ‘теленок (до года)’; бузаа *диал.* ‘теленок (*тодж.*); лосенок’. Распространена забайкальская фамилия БОЗИН(А) или БУЗИН(А), в основе которых, вероятно, лежит тувинский апеллятив именованья теленка. А вот такие имена как БАЖИГИ > БАЖИГИЕВЪ. БАЖИГИДАЕВЪ. БАЖОНО. БАЖИМИД. БАЖУ могут иметь разноязыкие объяснения: 1. От энец. базегу(сь) ‘расти’. 2. От хак. пазаним *кач.* ‘первый ребёнок’. 3. От тоф. бышыг ‘крепкий, прочный’. 4. От сойот. бышыг *прил.* ‘крепкий, прочный, закаленный’. При этом в Словаре имена БАЖОГУ КУРИЛДЕЙ. БАЖУГИЕВЪ мы даем как производные от энецкого базегу(сь) ‘расти’ [см.: 17]. Такие имена как БАЗАЙ > БАЗАЕВЪ, можно отнести и к энецким (от энец. базегу(сь) ‘расти’), так и к сойотскому бузаа [бузаасы] ‘новорожденный теленок (крупных домашних и диких копытных животных)’, лексически сопоставимое с шорским пыза ‘теленок (до года)’, тувинским бызаа ‘теленок (до года)’; бузаа *диал.* ‘теленок (*тодж.*); лосенок’. В тофаларском «осталась» лексема баьштаанай [баьштаанаэ] ‘оленок, родившийся раньше срока массового отела’ [см.: 6], которое, вероятно, имеет типологическое родство с именованьем теленка до года шорского, тувинского, сойотского языков.

Личные имена сойотского языкового происхождения — это такие имена как ХОВАРАКЪ ЛАМА ЖИШИ. ЖИШИ. ЖИЧИПОВЪ, значение которых связано с сойотским апеллятивом чаш~чаш *прил.* ‘новорожденный (ребенок, детеныш)’ или же от тофаларского чеш ‘1. новорожденный, грудной (о ребенке)’. Личное единичное имя ЗАЗИ [1, с. 223] объяснимо как от сойотского чаш~чаш *прил.* ‘новорожденный (ребенок, детеныш)’, так и от тофаларского чеш ‘1. новорожденный, грудной (о ребенке)’. К тому же в тофаларском чууча [чуучасы] также означает ‘дитя, малыш’ [6].

Ряд следующих личных имен ЗАЛПЕВЪ. ЗАЛА. ЗАЛАНЪ. ЗАЛБА. ЗАЛБУГИЕВЪ могут быть объяснены только от сойотского чалыы *прил.* ‘молодой, юный’ [7], что коррелирует в лексико-семантическом отношении с бурятским залуу ‘молодой, юный’. Мы не можем исключить и того, что в основе как сойотской, так и бурятской лексемы может «лежать» исходное именование новорожденного, поэтому «напрашивается» сравнение с селькупским апеллятивом ияля /тур./суц. ‘ребеночек’ [11]. Протетические явления в морфологии личных имен оказались довольно частотными, что демонстрирует как наличие былого билингвизма автохтонного населения, так и условный период «перехода» с одного языка на другой, в орбиту которого оказались «втянутыми» и имена собственные людей.

В частотном отношении весь свод имен при распределении стратиграфических пластов оказался неравнозначным. Так, почти около 80% всех мужских имен (следует отметить, что в ревизии 1830 года записаны только имена личные мужчин) оказались до-тибет-монгольского происхождения, тогда как тибет-монгольских имен намного меньше. Проиллюстрируем это положение следующими цифрами из анализа первых семи родов — Цаганского, Шараицкого, Батанай, Хальбин, Зунь-Хоацай, Зунь-Кубдутьского и Галзуут.

Таблица 2

Количество душ, семей и личных имен по родам

Название рода	Количество имен санскрит-тибетского происхождения	Количество имен бурят-монгольского происхождения	Всего семей // всего душ / единиц личных имен в роду
Цаганский	137 ед.	62 ед.	362 семьи / 1114 душ / ~ 1814 единиц имен
Батнай	135 ед.	33 ед.	458 семей / 1277 душ / ~ 1977 единиц имен
Барунь-Кубдуцкий	206 ед.	58 ед.	562 семьи / 1277 душ / ~ 1977 единиц имен
Зунь-Хоацай	208 ед.	62 ед.	1103 семьи / 1978 душ / ~ 2678 единиц имен
Шараицкий	203 ед.	56 ед.	582 семьи / 1672 души / ~ 2372 единицы имен
Хальбин	127 ед.	35 ед.	210 семей / 1011 душ / ~ 2372 единицы имен
Галзут	1521 ед.	136 ед.	789 семей / 2454 души / ~ 3154 единицы имен
Итого	2537 ед.	442 ед.	16 344 единицы личных мужских имен

Примерный подсчет единиц личных имен обусловлен суммой душ мужского пола + фамилии (+ ~ 700 ед.). У бурят до недавнего времени существовала двучленная система личных имен, т. е. имя эго + имя отца, поэтому примерное количество единиц мужских имен по семи из четырнадцати родов хоринских бурят включает все инварианты имен (формы имени), определенное в среднем ок. 700 единиц.

Особый интерес вызвал свод имен до-тибет-монгольского происхождения, составляющий естественное большинство. Из общего числа личных имен 7 родов хори-бурят, выписанных из ревизских описей за 1830 год, основной массив личных имен — это до-тибет-монгольские имена субстратного происхождения и составляют 15 682 единицы. Выявилось частотное наличие имен субстратного происхождения — самоедоязычного (селькупских, ненецких, нганасанских, энецких), юкагирияязычного, кетоязычного, тюркоязычного (чувашских, долганских, якутских, сойотских, тофаларских, шорских, тувинских, телеутских), дагурского, тунгусо-маньчжуроязычных (эвенского, эвенкийского, маньчжурского). Известно, что уже к ревизии 1858 года подавляющее число переписанных ясачных бурят имеют тибет-монгольские имена.

Наибольшее число личных имен хори-бурят, которые могут быть идентифицированы как имена эвенские, многие из которых явно переосмыслены в бурятском языке. Следует заметить, что в ономастике функционально значимы принципы дачи имени, имеются антропомодели в отношении значения имени. В случае отсутствия при определении антропонимического субстрата таких значений как «ребенок», «дитя» или «юноша, мальчик» значение данного имени не соответствует принципам номинации в антропонимике и является переосмысленным субстратным именем, значение которого надо искать в других языках, но не в бурятском. Поэтому именно эвеноязычные имена как до-тибет-монгольские имена личные хори-бурят всех без исключения 7 описанных родов являются ономастическим подтверждением тунгусо-маньчжурского субстрата в исторической антропонимии хори-бурят. Данные результаты согласуются с субстратной тунгусо-маньчжурской топонимией Восточного Забайкалья, где топонимические изоглоссы практически совпадают ареально с хоринскими землями, т.е. теми территориями, которые были заняты «инородцами» Хоринской и, позднее, Агинской степных дум. Данное разрешает некоторые вопросы и этногенеза хори-бурят. В этом плане бесценны роль и значение наличия и изучения семейно-родовых генеалогий как этнокультурных источников.

Литература

1. Жамсаранова Р. Г., Алтаева В. И., Бардаханова З. Д. Словарь исторической антропонимии хори-бурят: словарь / научный редактор Р. Г. Жамсаранова // Забайкальский государственный университет. Чебоксары: Изд-во Среда, 2022. 332 с. Текст: непосредственный.
2. Рассадин В. И. О тюркизмах в бурятском языке // К изучению бурятского языка. Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 1969. С. 130. Текст: непосредственный.
3. Жамсаранова Р. Г. Личные имена бурят рода Барунь-Кубдуд за 1830 г. / научный редактор Р. Г. Жамсаранова, З. Д. Бардаханова, В. И. Алтаева. Чита: Читинская городская типография, 2021. 158 с. Текст: непосредственный.
4. Жамсаранова Р. Г. Личные имена бурят рода Батнай за 1830 г. / редакторы Р. Г. Жамсаранова, З. Д. Бардаханова, В. И. Алтаева. Чита: Читинская городская типография, 2021. 122 с. Текст: непосредственный.
5. Жамсаранова Р. Г. Субстратные антропонимы в историческом именнике хори-бурят // Универсальное и специфичное в вербальных традициях народов современной России: Языки народов Сибири и сопредельных регионов: тезисы всероссийской научной конференции с международным участием. Новосибирск: Академиздат, 2020. С. 50–53. Текст: непосредственный.
6. Рассадин В. И. Словарь тофаларско-русский и русско-тофаларский: учебное пособие для учащихся средних школ. Санкт-Петербург: Дрофа, 2005. 296 с. Текст: непосредственный.
7. Рассадин В. И. Сойотско-бурятско-русский словарь / ответственный редактор И. Д. Бураев. Улан-Удэ: Республиканская типография, 2003. 180 с. Текст: непосредственный.
8. Малиновская С. М., Райская Л. М. Мотивационные признаки в древнеселькупском антропонимиконе // Вестник Сибири. 2012. № 5(6). С. 241–246. Текст: непосредственный.
9. Татаринцев Б. И. Этимологический словарь тувинского языка / ответственный редактор Д. А. Монгуш. Новосибирск: Наука, 2002. 388 с. (Т. II: Д, Ё, И, Й.). Текст: непосредственный.
10. Словарь нганасанско-русский и русско-нганасанский / составители Т. Ю. Жданова, Н. Т. Костеркина, А. Ч. Момде / ответственный редактор В. Ю. Гусев. Санкт-Петербург: Просвещение, 2001. 126 с. Текст: непосредственный.

11. Селькупско-русский диалектный словарь / под редакцией В. В. Быконя. Томск: Изд-во ТГПУ, 2005. 348 с. Текст: непосредственный.
12. Хакасско-русский словарь. Хакас-Орыс сөздігі. Ок. 20 000 слов / под общей редакцией О. В. Субраковой. Новосибирск: Наука, 2006. 1114 с. Текст: непосредственный.
13. Якутско-русский словарь. Ок. 25 300 слов / под редакцией П. А. Слепцова. Москва: Советская энциклопедия; Якутский филиал Сибирского отделения АН СССР. Инст-т языка, литературы и истории. 1972. 608 с. Текст: непосредственный.
14. Телеут-оруссөзлик. Телеутско-русский словарь / составители Л. Т. Рюмина-Сыркашева, Н. А. Кучигашева. Кемерово: АО Кемеровское кн. изд-во, 1995. 120 с. Текст: непосредственный.
15. Краткий дагурско-русский словарь / составители Г. Тумурдэй, Б. Д. Цыбенков. Улан-Удэ: Изд-во БНЦ СО РАН, 2014. 236 с. Текст: непосредственный.
16. Рассадин В. И. Очерки по истории сложения тюрко-монгольской языковой общности. Часть 1. Тюркское влияние на лексику монгольских языков / под редакцией Д. М. Насилова. Элиста: Изд-во Калм. ун-та, 2007. 166 с. Текст: непосредственный.
17. Энецко-русский словарь / авторы-составители И. П. Сорокина, Д. С. Болина. Санкт-Петербург: Наука, 2009. 488 с. Текст: непосредственный.

HISTORICAL ANTHROPNYMY OF KHORI-BURYAT

© **R. G. Zhamsaranova**

Doctor of Philological Sciences,
Associate Professor at Chinese Language Chair,
Transbaikal State University
Russia, Chita
rebeca_zab@mail.ru

Abstract. The article is devoted to the problem of studying the corpus of historical anthroponymy of the Khori-Buryat on the basis of censuses of 1830–1831, extracted from the documents of the State Archive of the Trans-Baikal Territory. The stratification of the set of personal names of the Khori-Buryats of 14 genera confirmed the presence of pre-Tibetan-Mongolian names as the most impressive layer of historical anthroponymy. A fairly large number of names were revealed, the meanings of which are explainable from the Samoyedic, Ket and Turkic languages of Siberia. The most impressive layer of anthroponyms in the pre-Tibetan-Mongolian stratum was the Even language substratum. These results are an indirect confirmation of the thesis of V.I. Rassadin about those native languages that influenced the formation of Buryat phonology from a historical perspective. Anthroponymic vocabulary, explained from appellative vocabulary, taking into account the nominative principles of onomastics, is able to confirm the key conclusions of well-known Mongolian scholars. Thus, the studied state of the historical anthroponymy of the Khori-Buryats allows us to “speak” not only about the composition of the nationality from the multi-ethnic components of the tribes of Siberia, but also to determine the phonological transformations in the morphostructure of the anthroponym in the Mongolian language environment. The studied historical anthroponymy of the Khori-Buryatkins gives basis to determine the prospects for studying the degree of mutual influence of structurally unrelated languages on the example of historical vocabulary (anthroponyms).

Keywords: censuses; Khori-Buryat; kins; historical anthroponymy; stratigraphy; multi-ethnic elements.

УДК 812+ 904

ДААХИЙН БИЧЭЭС
РУНИЧЕСКАЯ НАДПИСЬ В МЕСТНОСТИ ДААХЬ

© **Загарпэрэнлэй Түмэнбаяр**

Судлаач,
Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэн
Монгол Улс, Улаанбаатар хот
zagaraa0904@gmail.com

© **Содномжамц Дамчаабадгар**

Судлаач,
Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Археологийн хүрээлэн
Монгол Улс, Улаанбаатар хот
sodnomjamts.num@gmail.com

Хураангуй: Бид энэхүү илтгэлдээ Өвөрхангай аймгийн Өлзийт сумын нутгаас шинээр илрүүлсэн руни бичгийн нэгэн дурсгалын уншлага, судалгааг толилуульж байна. Монгол Улсын Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Д. Содномжамц 2022 оны 8-р сард тухайн нутагт хийсэн хээрийн хайгуул судалгааны ажлын хүрээнд тус бичээсийг анх илрүүлжээ. Бичээсийг цайвар шаргал өнгийн боржин хадан цохионд, хадны өнгөн хэсгийг холцруулан цохих аргаар бичжээ. Тиймээс үсэгт тэмдэгт гүн бус ч ялгарч тод харагдах ажээ. Руни бичгийн энэхүү шинээр илэрсэн дурсгал нэг мөр, таван үсэг тэмдэгтээс бүрдэх бөгөөд бичээст шууд холбогдох нэг тамгатай. Тус бичээс үсэг тэмдэгт цөөн, хэмжээний хувьд багахан, түүхэн чухал үйл явдал тэмдэглэгдээгүй боловч эртний Түрэг, Уйгурын үеийн үсэг бичиг, үгийн сан судлалд чухал дурсгалд зүй ёсоор тооцогдож байна.

Бид энэхүү судалгаандаа бичээст гарах үгсийн утгыг тайлбарласнаас гадна Монголын руни бичгийн бусад дурсгалуудад ямар утгаар, хэрхэн тохиолдож буй давтамжийг тодруулж тухайлан өгүүлэхийг хичээлээ.

Бичээст шууд холбогдох тамга, түүний тархцын талаар товч дурдав. Тамгаар баримжаалбал, бичээсийг Уйгурын хаант улсыг байгуулалцсан Карлук аймгийн хүн бичиж үлдээсэн байх боломжтой бөгөөд он цагийн хувьд ч мөн энэ үед холбогдох бололтой.

Түлхүүр үг: Даахийн бичээс, руни бичиг, үсэг бичиг судлал, Түрэг судлал, хэл шинжлэл

Өвөрхангай аймгийн Өлзийт сумын төвөөс баруун урд зүгт 21 км зайд Өлзийт хайрхны зүүн хойд талд орших боржин чулуун тогтоцтой хадан цохио бүхий газрыг нутгийн ардууд Даахь [Зураг 3] хэмээн нэрлэдэг. Даахийн цохионы урд тал хуучин бууцны үлдэгдэл бүхий чулуун хашаатай ба зүүн урд талд орших жижиг нуурыг Даахийн нуур гэнэ. Бичээсийн оршиж буй газар нь гурван хэсэг хадан цохио бүхий бөгөөд зүүн урд талын цайвар шаргал өнгийн боржин чулуунаа уг бичээс бий [Зураг 4]. Гурван үе давхарлаж тогтсон тогтоц бүхий хадан цохионы дунд үе давхаргын тэгш гадаргууд уг бичээсийг бичсэн нь одоо ч харьцангуй тод харагдах ажээ.

Хадан цохио олон зуун жилийн нар салхи, бороо цасны ус чийгт элэгдсэн байгалийн элэгдэл, хорогдлоос гадна, чулууны насжилтаас шалтгаалж бүхэлдээ хагарсан, холцорч унасан, цаашдаа ч хагарч, цуурч холцорч унах эрсдэл өндөр байгааг онцлон тэмдэглэх нь зүйтэй болов уу.

Дурдсан хадан цохион урагш харсан тэгш гадаргуу дээр бичсэн нэг мөр, таван үсэг тэмдэгт бүхий руни бичээсийг бид “Даахийн бичээс” [Зураг 5] хэмээн нэрлэж судалгааны эргэлтэд оруулж байна.

Монголын руни бичгийн дурсгалын судалгааны тойм, холбогдох бусад ном бүтээл, эрдэм шинжилгээний тайлан, эх хэрэглэгдэхүүнүүдэд уг бичээсийн талаар тэмдэглэсэн, дурдсан зүйл хараахан үгүй учир бид шинээр илрүүлсэн бичгийн дурсгал мөн хэмээн үзлээ.

Даахийн бичээсийн үсэг тэмдэгтийн өндөр дунджаар 16 см, өргөн нь 4–6 см байх ажээ. Тус бичээсийн мөрийн эхэнд нэг тамга байх бөгөөд маш тод тодорхой дүрслэлтэй. Уг тамганы өндөр 40 см, өргөн нь 26 см.

Тамга цохиж улмаар үргэлжлүүлэн бичээс бичсэн бололтой бөгөөд тамга, бичээсийн нийт урт 60 см байна.

Боржин чулуун тогтоцтой гурван хэсэг хадан цохио бүхий хаданд ихэвчлэн хүрэл зэвсгийн үед холбогдох цөөн тооны хадны зурагтай бөгөөд бид хожмын судалгаандаа хадны зургийн талаар тухайлан өгүүлэх болно.

Хамрагдах ангилал: Монгол нутгаас олдсон руни бичгийн дурсгалуудын ангилалын тухайд эрдэмтэн Ц. Баттулга өөрийн саналыг дэвшүүлсэн байдаг. Тэрээр “*руни бичгийн дурсгалыг чухам юун дээр бичиж тэмдэглэсэнд тулгуурлан*” (Ц. Баттулга, 2020: 20), “1. Хөшөөний бичээс, 2. Хадны бичээс, 3. Чулуун дээрх бичээс, 4. Мэлхий чулуун дээрх бичээс, 5. Тахилын хавтангийн бичээс, 6. Буган чулуу дээрх бичээс, 7. Хүн чулууны бичээс, 8. Модон эдлэл дээрх бичээс, 9. Ясан эдлэл дээрх бичээс, 10. Шавар вааран эдлэл дээрх бичээс, 11. Металл эдлэл дээрх бичээс” (Ц. Баттулга, 2020: 20) хэмээн ангилсан байдаг. Энэхүү ангилал нь Монгол нутагт оршиж буй 180 гаруй руни бичээсийг бичигдсэн зүйл дээр нь тулгуурлан хийсэн хамгийн бодтой ангилал гэж үзэж байна. Энэхүү ангилалаас үзэхэд 2020 оны байдлаар Монгол нутаг дахь нийт руни бичээсийн дийлэнх нь буюу 121 бичээс нь (Ц. Баттулга, 2020: 21) хадны бичээст хамаарагдаж байжээ.

Харин бидний уншлага, судалгааг нь шинээр толилуулж буй бичээс цайвар шаргал өнгийн том ширхэгтэй боржин хадан цохионоо бичигдсэн учир тухайн ангилалын дагуу хадны бичээст хамаарагдана гэж үзэж байна. Бидний нийтлүүлж буй эл бичээсээс гадна “*Сүхбаатар аймгийн Баяндэлгэр сумын төвөөс 22 км зайтай орших Таван толгой хэмээх баруунаас зүүн тийш чиглэсэн цувраа дэл хадтай толгой...*” - ноос (Р. Мөнхтулга, 2022: 35, 36) руни бичгийн нэгэн шинэ дурсгал мөн олдсон бөгөөд тухайн бичээсийг Р. Мөнхтулга уншиж “Таван толгойн бичээс” нэртэйгээр нийтлүүлсэн байна (Р. Мөнхтулга, 2022). Нийтлүүлсэн судалгаанаас үзэхэд тухайн бичээс нь мөн хадны бичээсийн ангилалд хамрагдах бололтой. Ийм учир Монгол нутгаас олдсон хадны бичээсийн нийт тоо 123 болж байна.

Мөн эрдэмтэн Ц. Баттулга, “...*Чулууны бичээст хүн өргөж зөөж болохуйц чулуунд бичиж үлдээсэн дурсгалуудыг оруулав. Хадны бичээст багтах нэг төрөл мөн боловч нэгэнт анхны байрлалаас хөдөлгөж, хол ойр зөөсөн тул “чулууны” гэж тодорхойлж тодотгохоос өөр аргагүй. Энэ төрлийн дурсгал голдуу музейд хадгагдаж байна. Чулууг зассан, эс зассаныг үл харгалзан энэ ангилалд оруулав*” (Ц. Баттулга, 2020: 20) хэмээжээ.

Хамрагдах төрөл: Монгол нутаг дахь руни бичээсийг бичлэгийн агуулга, хэмжээгээр нь сонгодог болон бага дурсгал хэмээн ерөнхий хоёр зүйл болгон авч үздэг. Бидний судалж буй дурсгал нь руни бичгийн бага дурсгалд хамаарна. Эдгээр бага бичгийн дурсгалуудыг эрдэмтэн Ц. Баттулга, бичиж үлдээсэн арга,

бичлэгийн тиг хэлбэрт тулгуурлан *сийлмэл бичээс, цохимол бичээс, зураасан болон зурчмал бичээс, бэхэн бичээс, хөөмөл бичээс* (Ц. Баттулга, 2020: 21) хэмээн нийт дөрвөн төрөлд ангилан судалсан байна. Энэ ангилал нь одоогоор Монголын руни бичгийн дурсгалыг цогцоор нь судалж буй эрдэмтний хийсэн хамгийн бодтой ангилал юм. Даахийн бичээс нь энэхүү ангилалын “цохимол бичээс”-ийн төрөлд хамаарч байна. Өөрөөр хэлбэл, цохимол бичээсийн “үсэг тэмдэгийг бичихдээ хад, чулууны өнгөн хэсгийг холцруулж, гүнзгий бус цохиж үлдээсэн бичээс”-ийн (Ц. Баттулга, 2020: 21) төрөл бөгөөд уг бичээс нь “*тодорхой мэт харагдах боловч ихэнх тохиолдолд дардас авах боломжгүй байдаг*” (Ц. Баттулга, 2020: 21) ажээ. Даахийн бичээсийг өндөр цохион хадны тэгш гадаргуу дээр өнгөц цохиж бичсэн нь тод харагдана. 2020 оны байдлаар Монгол дахь руни бичгийн нийт 158 (Ц. Баттулга, 2020: 22) бага дурсгал байсан бол бидний энэхүү Даахийн бичээс болоод дээр дурдсан “Таван толгойн бичээс” нэмэгдэж, бага дурсгалын нийт тоо 160-д хүрч байна. Харин цохимол бичээсийн тоо 2020 онд 57 (Ц. Баттулга, 2020: 22) байсан бол Даахийн бичээс нэмэгдэж нийт 58 болж байна.

Бүс нутаг дахь бичээсүүд: Одоогийн байдлаар Өвөрхангай аймгийн [Зураг 2] нутгаас нийт руни бичгийн 5 дурсгал илэрч олдсоны дотор Уянга сумын Онгийн гэрэлт хөшөө, Нарийнтээл сумын Тавьтын бичээс, Богд сумын Тэгшийн (Тэвш) улааны бичээс, Баруунбаян-Улаан сумын Хутаг уулын бичээс болон аймгийн музейд олдсон газар нь тодорхойгүй Өвөрхангайн бичээс нэртэй дурсгал тус тус багтана (Ц. Баттулга, 2022: 182–197). Харин Өлзийт сумын Даахийн бичээс нь тус аймгийн нутгаас олдсон руни бичгийн зургаа дахь дурсгал болно.

Үсэг зүй: Руни буюу эртний түрэг бичээс нь зөв бичих зүй тогтлын хувьд маш төгөлдөржсөн тухайн үеийн Түрэг, Уйгурын хаант улсын төрийн бичгийн хэл байсан нь ялангуяа сонгодог дурсгалуудаас тодорхой ажиглагддаг. Тухайлбал, эр болоод эм үгийг эгшиг, гийгүүлэгчээр нь ялган бичдэг төдийгүй, уншлага, дуудлагын хувьд ижилхэн, үүргийн хувьд ялгаатай дагавар нөхцөлийг ялган тэмдэглэсэн байдаг. Энэ нь тухайн үгийг авианы түвшинд ялгаж буй хэлбэр бөгөөд бичгийн хэлний хөгжлийн дээд түвшнийг илтгэнэ. Даахийн бичээс нь нийт таван зурлага үсгээс бүрдэх бөгөөд тухайн үсгүүдийн нэгээс бусад нь тодорхой, бичлэгийн түвшинд нэлээд тогтворжсон үед бичигдсэн болох нь ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл бичээс бичгийн сонгодог хэлбэрээ олчихсон байх үед бичигджээ. Харин бичээсийн төгсгөлийн нэгэн зурлага үсэг нь төдийлөн тодорхой бус байна. Энэ учир бид тухайн бичээснээ тун балархай тохиолдож буй төгсгөлийн гийгүүлэгч үсгийг сайн нягталж, бичээсийн хоёр дахь үгийн эхний “*çu-*” язгуураас хөөн, эр үгийн [r] R гийгүүлэгч байх магадлалтай хэмээн үзэж байна. Ийм болбоос тухайн үг нь эртний Түрэгийн ялангуяа Уйгурын хаант улсын үед идэвхтэй хэрэглэгдэж байсан “чур” хэмээх цол болох юм.

Бичээсийн уншлага:

Эхийн сийрүүлэг: гос гК

Үсгийн галиг: Q R ё W R

Үгийн галиг: Кар ёг

Орчуулга: Кар Чур ~ Кар[a] Чур

Кар[а] Чур хэмээхийн тухай: Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших Дээд цохиотын бичээст “...qar čur...” (Ц. Баттулга, 2022b: 139) хэмээн тохиолдох бөгөөд энэ нь бидний судалж буй Даахийн бичээстэй утга агуулгын хувьд ижилхэн байгаа нь ихээхэн анхаарал татаж байна. Өөрөөр хэлбэл тухайн бичээсийг хоёр өөр газарт нэг хүн бичсэн байх магадлалтай. Баянхонгор аймгийн Галуутын сумын нутагт орших Дээд цохиотын бичээс нь тухайн үеийн Түрэг, Уйгурын хаант улс одоогийн Монгол улсын Архангай, Өвөрхангай аймгийн нутагт тодруулбал Орхоны хөндийд нийслэлээ байгуулсантай шууд холбоотой байж болох юм. Өөрөөр хэлбэл Орхоны хөндийд улсаа байгуулсан Түрэг, Уйгурын улсаас баруун зүг зорчих их зам дагуух маршрут нь одоогийн Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрээр дайрч өнгөрдөг байсан тухай эрдэмтэн Ц. Баттулга өөрийн бүтээлдээ өгүүлсэн байдаг (Ц. Баттулга, 2022a: 51). Мөн тэрээр Дээд цохиотын бичээсийн тухай “...уг бичээсийн эхний гурван тэмдэгт маш тодорхой, харин төгсгөлийн тэмдэгт ихэд бүдгэрсэн байна” хэмээгээд “юутай ч түрэг, уйгурын үед Хар (kar, kara) нэрт чур (čur) цолтой нэгэн үүгээр дайрч өнгөрөхдөө өөрийн нэр цолоо бичжээ. Үүний учир аян замын тэмдэглэл”-ийн төрөлд багтах бичээс хэмээн үзэж болох юм” (Ц. Баттулга, 2022b: 139–140) хэмээн өгүүлсэн байна. Өөрөөр хэлбэл тухайн үед одоогийн Монголын төв нутгаас баруун тийш торгоны зам явахдаа буудаллаж, амарсан үедээ хаднаа өөрсдийн нэр, цолыг бичдэг байжээ. Энэ нь Монголын руни бичгийн бага дурсгалуудаас нилээд тодорхой харагддаг.

Харин Өвөрхангай аймгийн Өлзийт сумын нутгаас олдсон Даахийн бичээс нь Орхоны хөндийгөөс өмнө зүгт зорчих зүүн өмнөд салбар зам дагуух бичгийн дурсгал бололтой. Өөрөөр хэлбэл Кар ~ Кара нэрт Чур цолтон нь Түрэг эсвэл Уйгурын хаант улсын үед Орхоны хөндийгөөс өмнө зүгийн улс орон руу зорчихдоо тус газраар дайрч, өөрийн нэр цолыг (овгийг) бичиж эсвэл бичүүлж үлдээсэн байх боломжтой байна. Адилхан бичигдсэн тус хоёр бичээсээс үзэхэд Кар ~ Кара Чур нь Түрэг эсвэл Уйгурын хаант улсын төрийн албанд зүтгэж байсан нэг хүний үлдээсэн бичгийн дурсгал бололтой. Мөн Түрэг болоод Уйгурын хаант улсын үед Чур цолтонгууд (овогтонгууд) төрийн зарлиг, тушаал болоод мэдээг өөр улсад албан ёсоор хүргэдэг элч төлөөлөгчийн үүргийг гүйцэтгэдэг байсан байж болох юм. Ингэвэл “чур” хэмээхийг цол хэмээн үзэхээс илүүтэй аль нэг “овог, аймагт” үүргээр өгсөн нэр гэж үзвэл зохилтой. Өөрөөр хэлбэл, Түрэг, Уйгурын хаант улсын үед Чур овогтонгууд төрийн бичгийг түгээх үүргийг хүлээдэг байжээ. Тийм учраас баруун, зүүн, өмнөд тийш зорчих төв зам дагуу чур овогтой (цолтой) хүмүүс илүү зорчиж, нэр алдараа бичиж үлдээсэн байна. Ингэвэл энэ нь тухайн үеийн төрийн тогтолцоо, системтэй шууд холбогдоно.

Мөн Өвөрхангай аймгийн Баруун Баян-Улаан сумын нутагт орших Хутаг уулын 1-р бичээсийн 1-р мөрнөө “...qara karkü)~käräkü) täṅrikän” (Ц. Баттулга, 2022b: 194) хэлбэрээр Кар ~ Кара хэмээх үг тохиолдож байна. Монголын нийт руни бичгийн бага дурсгалуудад Кар ~ Кара хэмээх нэр гурван газарт давтагдаж байгаа нь тухайн бичээсүүдийг нэг хүн бичсэн байх магадлалтай бөгөөд төрийн бичиг, зарлигийг хүргэх үүргийнхээ хүрээнд явж байхдаа аян замдаа бичиж үлдээсэн байх боломжтой байна.

Бичээс тохиолдож буй оноосон нэр байх боломжтой “qar” хэмээх нь монгол, түрэг хэлний дундын шинжтэй “qara” хэмээх үгтэй холбоотой байх боломжтой юм. Хэрэв тийм бол “qar ~ qara” хэмээх нь тухайн хоёр хэлнээ ижил утгыг илтгэж байна. Өөрөөр хэлбэл сонгодог монгол хэлнээ “qar-a” (Я. Цэвэл, 1966: 660) бөгөөд орчин

цагийн монгол хэлнээ “хар” (МХЖТ, 2019: 363) хэлбэрээр тохиолдоно. Утга нь 1. цагааны эсрэг хөө, [жишээ нь:] нүүрсний өнгө, хар будаг, хар савхин гутал, хар гэртээ хаан, бор гэртээ богд, 2. муу санаа, хорон санаа, хорт муу үйл, [шилж.] 3. яршиг удсан, чирэгдэлтэй, [жишээ нь:] хар бороон дундуур, хар өглөөгүүр, 4. төрийн, шашны биш, [жишээ нь:] хар хүн ~ эр, эм бололцогчдын эрий нь, төрийн хар хүн [шилж.], 5. ганц, өөрийн, хувиа [жишээ нь:] хар бие ~ганц бие, хар толгойдоо гомдох, хар амиа бодох [шилж.] (Я. Цэвэл, 1966: 660-661) болох юм.

Харин эртний түрэг хэлнээ тухайн үг нь үйл болоод нэр үгийн утгаар тохиолдоно. “qar” нэр үгийн утгаараа 1. снег (цас), 2. Верхняя часть руки, плечо (гарын дээд хэсэг, мөр), 3. qar qur et... (хар хур дуу гарах) тухайлбал, гэдэс хоржигнох, үйл үгийн утгаараа “qar-” 1. смешивать, примешивать (~холих, хутгах), 2. поперхнуться, подавиться (~живэх, умбах), 3. переливаться через край (~[гол, нуурын] эргээс зөөх, гаталгах), выходит из берегов (~эргээс зөөх, гаргах), разливаются (~асгарах) гэх мэт утгаар (В. М. Надеяев *нар*, 1969 :422) тохиолдож байна. Харин “qara” хэлбэрээрээ 1. Черный (~хар), 2. темный (~харанхуй), лишенный света (~гэрэлгүй, гэгээгүй), погруженный во мрак (~харанхуйд живсэн, ууссан) 3. Злощастный, злополучный (~азгүй, золгүй) [шилж.], 4. плохой (муу муухай, хорон) [шилж.], 5. обыкновенный, для повседневных (~энгийн, өдөр тутмын) [шилж.] (В. М. Надеяев *нар*, 1969: 422–423) гэх мэт утгаар өргөн тохиолдох ажээ. Үүнээс гадна “qara” нь 2. масса, толпа (~ард олон, ард түмэн), тухайлбал, qara bodun, qara bülük, qara qamцү, 3. компонент (~[өгүүлбэрийн эзэн биеийн] бүрэлдэхүүн)-ий утгаар тохиолддог байна. Тухайлбал, qara baqši, qara buqa, qara kol, qara qan гэх мэт.

Үүнээс үзэхэд тухай үг нь монгол, түрэг хэлнээ нэр болоод үйл үгийн үүргээр маш идэвхтэй хэрэглэгддэг байна. Тухайн үг нь эл хоёр хэлний дундын шинжтэй үг гэдэгт маргах аргагүй. Ялангуяа өнгөний нэр заах утгаараа тухайн хоёр хэлнээ өнөө ч адилхан утгыг илтгэхээс гадна бичлэгийн хэлбэрээ ч алдаагүй байна. Харин “qar-” хэмээх үйл язгуур ихэд анхаарал татна. Эртний түрэг болоод орчин цагийн түрэг хэлнүүдэд тухайн үйл язгуураас үүссэн олон нэр болоод үйл язгуур бий. Үүнийг бид Карчур~Карачур хэмээх хүмүүнтэй холбогдож болох нэгэн аймгийн нэртэй холбон тайлбарласныг “чур” хэмээхийн дараа үзнэ үү.

Харин “чур” овогтой (цолтой) хүмүүсийн нэрс Монголын баруун, төв, хойд, өмнөд, зүүн бүс нутгаас нилээдгүй илэрч байна. Эдгээрийг сийрүүлбэл, Баруун бүс нутгаас Говь-Алтай аймгийн Бигэр сумын нутагт орших Бигэрийн 1-р бичээст “**čur** aqar uoli” (Ц.Баттулга, 2022а: 108), Шаахар толгойн 1-р бичээст “... bal **čur** ...” (Ц. Баттулга, 2022а: 130), Дарвийн 1-р бичээст “... ay **čur** ...” (Ц.Баттулга, 2022а: 177), Дарвийн 2-р бичээст “... ay **čur** ...” (Ц.Баттулга, 2022а: 177), Ямаан усны хавцлын ханан хадны 1-р бичээст “... kün **čur** ...” (Ц. Баттулга, 2022а: 214) гэх мэт нийт 5 удаа тохиолдож байна.

Харин төвийн бүс нутгаас Архангай аймгийн Ихтамир сумын нутагт орших Тайхир чулууны 3-р бичээсийн 1-р мөрнөө, “bilgä tarduš alp **čur** ...” (Ц. Баттулга, 2022b: 42), 24-р бичээсийн 3-р мөрнөө “... k...k **čurum** ...” (Ц.Баттулга, 2022b: 46 II), 30-р бичээсийн 3-р мөрнөө “... tard[u]š kül **čur** ...” (Ц.Баттулга, 2022b: 48), Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хавцгайтын хавцлын бичээст “... qarliü **čur** ...” (Ц. Баттулга, 2022b: 124) мөн аймгийн Хиргисийн овооны бичээсийн өмнө талын 2-р мөрнөө “... tuta yägän **čur** ...” (Ц.Баттулга, 2022b: 124), зүүн талын мөрнөө “... bilgä **čurim**γa : t[oqitdim]” (Ц.Баттулга, 2022b: 128), Галуут сумын ну-

тагт орших Дээд цохиотын бичээст “... qar **čur** ...” (Ц. Баттулга, 2022b: 139), Өвөрхангай аймгийн Тэгшийн улааны (тэвш) бичээснээ “... уауыз **čur** ...” Ц. Баттулга, 2022b: 192), Баруун Баян-Улаан сумын нутагт орших Хутаг уулын 1-р бичээсийн 2-р мөрнөө “... yägän **ančur** ...” (Ц. Баттулга, 2022b: 194), 2-р бичээснээ “... ükük **čur** ...” (Ц. Баттулга, 2022b: 196), Өлзийт сумын нутагт орших Даахийн бичээснээ “kar **čur**”, Төв аймгийн Лүн сумын нутагт орших Улаан чулууны 4-р бичээсийн 1-р мөрнөө “... qaua **čur**...” 3-р мөрнөө “... bāṅlig **čur**...” (Ц. Баттулга, 2022b: 223) хэмээн нийт 13 удаа тохиолдож байна.

Мөн монголын зүүн бүсээс Говьсүмбэр аймгийн Чойрын хүн чулууны бичээсийн 4-р мөрнөө “... tun bilgä **čur**...” (Ц. Баттулга, 2022c: 49) хэмээн 1 удаа тохиолдож байгаа бол өмнөд бүсээс Өмнөговь аймгийн нутгаас олдсон Хотгорын зараа толгойн бичээсийн 1 болон 2-р мөрнөө “taṅ **čur**...” (Ц. Баттулга, 2022c: 116) хэмээн 2 удаа тохиолдож байна.

Энэ бүх тохиолоос үзэхэд “чур” хэмээх нь Монголын руни бичгийн бага дурсгалуудад нийт 20 удаа тохиолдож байгаа нь сонирхол татаж байгаа юм. Үүнийг цаашид нэхэн үзвэл зохилтой.

Карчур~Карачуртай холбогдох боломжтой эртний түрэгийн нэгэн овог байгаа нь бидний сонирхолыг татаж байна. Тухайн овог нь эртний Түрэгийн хаант улсыг (I, II) бүрдүүлж байсан чухал овгийн нэгэн бөгөөд хятад сурвалжид 葛邏祿 (gélùólù), исламын шашинт араб хэлээрх бичгийн дурсгалд حارلوق (harluq), перс хэлээрх бичгийн сурвалжид حالوه (halluh), төвд хэлээрх сурвалжид garlog, харин монгол бичгийн дурсгалд “qarlu’ud” (С.Мөнхсайхан, 2020: 108) буюу “харлугууд” хэмээн тохиолддог байна. Энэ нь Бэшбалык хотын баруун хойгуур тухайлбал, Алтай нурууны баруун тал Хар эрчис мөрөн, Тарвагтайн нуруу орчимоор төвлөн нутаглаж байсан (I. A., 2001: 509) “Карлук” аймаг юм.

Эл аймгийн тухай хятад бичгийн сурвалжуудад анх 605 онд тэмдэглэсэн бөгөөд Карлукууд нь Түрэгийн хаант улстай (I) холбоотон аймгуудын тоонд багтаж (A. Taşagıl, 2014: 76) байжээ. Үүнээс хойш 745 он буюу Түрэгийн хаант улс (II) мөхөх хүртэлх хугацаанд түүхэн олон үйл хэрэгт оролцсон тухай сурвалж бичгүүдэд тэмдэглэгдэн үлдсэн байна. Карлугууд мөн л түрэг угсааны болох Басмил болон Уйгур аймгуудтай нэгдэн Түрэгийн хаант улсыг (II) 744 онд (A. Taşagıl, 2013: 67) бүрэн эзэлсэн байдаг. Тэд дундаасаа Басмилийн тэргүүлэгчийг хаанд өргөмжилжээ. Улсын баруун жигүүрийг Карлугууд, зүүн жигүүрийг Уйгурууд тэргүүлэх болов. Төдөлгүй Уйгурууд тухайн үеийн Тан улстай үгсэн дараа нь Карлугуудыг эгнээндээ нэгтгээд Басмилаас суусан хааныг хөнөөсөн байна (A. Taşagıl, 2013: 67). Түүхэн сурвалжуудад Карлугуудтай холбоотой түүхэн баримтыг хөөн үзвэл ихэд сонирхолтой байна.

Үүнээс хойш Карлугуудтай холбоотой байж болох нэгэн чухал мэдээ МНТ-ноо, ...naiman-u Gücülük qan Uiyurtai **Qarlu’ud-i** (Харлугудыг) da’arin Sarda’ul-un qajar-a Čui müren-e bükün Qara Kidad-un Gür qan-tur neyilen otču’ui... §198, ...**Qarlu’ud-un** (Харлугудын) Arslan qan Qubilai-tur elsen irejü’üi... §235, ...qubilai noyan-i **Qarlu’ut-tur** (Харлугудад) ča’ura’ulba... §235 (С. Мөнхсайхан, 2020: 1040) хэмээн нийт гурван удаа тохиолдож байна. Үүнээс ажиглахад 8-р зууны үеийн эртний түрэгээр бичигдсэн сонгодог дурсгалуудад тохиолдож буй **qarluk**~Карлук (түр.) аймаг нь хожмоо 13-р зууны үед монгол хэлээр бичигдсэн чухал дурсгалд **qarluy**~Харлук (мо.) хэлбэрээр тохиолдож байгаа нь ихэд сонирхолтой. Тухайн үгнээ бичлэгийн болоод агуулгын өөрчлөлт гараагүй байна.

Өөрөөр хэлбэл энэ нь нэг аймаг ажээ. Тэрчлэн монголчууд карлуг~Харлугуудыг маш эртнээс мэддэг байсан нь тодорхой байна. 8-р зуунд Басмил, Уйгур нартай хамтран хүчирхэг Түрэгийн хаант улсын эзэлж явсан тэд Уйгуруудтай харилцаагаа удаан хадгалж чадаагүй нь түүхэн сурвалжуудад тэмдэглэгдсэн байдаг. Тэд Түрэгийн хаант улсыг буулгаж авсан үеэс эхлээд улсын баруун жигүүрийг мэдэж байсан тухай дээр дурдсан. Тэгвэл МНТ-ноо Чингис хаан баруун зүгийг хэрхэн дайрлаар мордсон тухай маш тодорхой өгүүлсэн бөгөөд энэ хэсэгт Карлукуудын тухай: “...*Найманы Хүчүлүг хан, Уйгурдай Харлугуудыг дайран, Сартуулын газраа (газарт) Чүй мөрнөө бүхүн Хар Хятаны Гүр ханд нийлэн оджухуй, §235. Хубилай ноёныг Харлугуудад чагууруулав, Харлугуудын Арслан хан Хубилайд элсэн иржэхүй*” (Ш. Чоймаа, 2011) хэмээн тохиолдоно. Үүнээс ажиглахад үйл явдал өрнөж буй газар нь одоогийн Шинжаан Уйгур, Зүүнгарын тал, Амударьяа, Сэрдарьяа мөрний ай сав бололтой. Өөрөөр хэлбэл Карлукууд Уйгурын хаант улсыг мөхсөний дараа ч 13-р зуун хүртэл 8-р зууны үеийнх шигээ баруун жигүүрийн нутгаа захиран, уугуул газар нутагтаа нөлөөгөө алдаагүй байжээ.

Харин **qarluk**~Карлуг хэмээх үгийн тухай өгүүлбэ. Бид тухайн үгийн язгуурыг “**qar-**” хэмээх үйл язгуураас үүсэлтэй гэж үзвэл энэ нь дээр дурдсан 1. *холих, хутгах*, 2. *живэх, умбах*, 3. *[гол, нуурын] эргээс зөөх, гаталгах* гэсэн утгуудтай. Эдгээр утгаас “холих, хутгах” хэмээх утга нь илүү тохиромжтой. Тэгвэл “**qar-**” язгуурын дараа залгагдаж буй **+luk** нь “аливаа зүйлийг агуулах, бүхий” гэсэн утгыг илтгэдэг нэрээс нэр үг бүтээх дагавар юм. Ийм учир тухайн язгуурыг үйл язгуураар хүлээн зөвшөөрөх боломжгүй бололтой. Хэрэв зөвшөөрөл тухайн үйл язгуурт үг нь “холдсон, хутгагдсан” гэх утгыг илтгэх байжээ.

Энэ учир “**qar**” хэмээхийг нэр язгуур гэж үзвэл илүү тохиромжтой. Өөрөөр хэлбэл 1. *цас*, 2. *гарын дээд хэсэг, мөр*, 3. *хар хур дуу гарах* гэсэн утгуудаас “цас” хэмээх нь илүү тохиромжтой. Ингэвэл “**qar+luk**” буюу “цастай, цас бүхий” гэсэн утгыг илтгэнэ. Өөрөөр хэлбэл тэднийг нүүдэлчид эртнээс амьдардаг газар нутгаар нь төлөөлүүлэн нэрлэдэг байсан байж болох юм. Түүхэн сурвалжаас бид тэндийг “*Бэшбалык хотын баруун хойгуур тухайлбал, Алтай нурууны баруун тал Хар эрчис мөрөн, Тарвагтайн нуруу орчим*” нутагладаг байсан тухай дээр өгүүлсэн билээ. Тэдний амьдарч асан энэ газар нь өндөрлөг уулсаар хүрээлэгдсэн намар, өвөл, хаврын цагтаа цас их унадаг бүс нутаг юм. Тийм учир тэд өөрсдийгөө эсвэл тэднийг “**qar+luk**” буюу “цаст газрынхан, цастууд” хэмээн нэрийдсэн байх бүрэн боломжтой байна.

Тамга [Зураг 5]: Энэ төрлийн тамгатай төстэй дүрслэлүүд Булган аймгийн Сайхан сумын Моюнчурын гэрэлт хөшөө (Б. Азаяа, 2013), Баян-Агт сумын Шивээт улаан (А. Энхтөр, С. Далантай, 2018), Төв аймгийн Бүрэн сумын Бичигт улаан хад зэрэг газруудын тамгатай ижил байна. Мөн Архангай аймгийн Их Тамир су-мын Тайхар чулуу, Хэнтий аймгийн Батширээт сумын Рашаан хад, Баянхон-гор аймгийн Бууцагаан сумын Гурван мандал, Баянжаргалан сумын Мөрт уул, Билгэ хааны тахилын онгоны балбал чулууны тамга (Д. Батсүх, 2004) зэрэг газруудад Даахийн тамгатай төстэй дүрслэл бий. Дээрх дурсгалуудын дотроос Моюнчурын гэрэлт хөшөөн дээрх тамгыг ихэнх судлаачид Уйгурын Яглагар (药罗葛 — yao luo ge) овгийн тамга хэмээн үздэг. Учир нь Уйгурын хаант улсын эхэн үед Яглакар аймаг төр барьж байсан бөгөөд Моюнчур бол тус овгийн хоёр дахь хаан юм. Тиймээс гэрэлт хөшөөний магнай хэсгийн гол хэсэгт өөрийн овгийн тамгаа сийлж үлдээжээ. Үүний нэгэн адилаар Даахийн бичээсийн эзэн болох



“Хар[а]чур/Кар[а]чур” нь өөрийн овгийн тамгаа сийлж үлдээсэн бололтой. Бид дээр өгүүлсэн судалгаандаа үндэслэн тухайн тамга нь Уйгурын хаант улсыг байгуулахад хамтран зүтгэсэн гол гурван аймгийн нэг Карлук~Харлуг аймгийн тамга бололтой гэж үзэж байна. Өөр хэлбэл бичээсийг үйлдсэн Карчур~Карачур нь Уйгурын хаант улсын эхэн үед амьдарч байсан нэгэн бөгөөд шинэхэн Уйгурын хаант улсыг байгуулалцахын төлөө тэмцэж явсан нэгэн бололтой. Тэр дундаа улсын баруун жигүүр мэдэж асан Карлук аймгийн хүн байсан бололтой. Мөн тухайн тамга нь Уйгурын гол овгийн тамгатай нилээд төстэй байгаа нь магадгүй Уйгурын хаант улсыг байгуулсан Карлук, Басмыл, Уйгур аймгуудын тамга нь хоорондоо ижил төстэй байсан байх боломжтой байна. Тухайн тамганы тухай цаашид гүнзгийрүүлэн судлах нь зүйтэй.

Дүгнэлт

Тухайн бичээсийг үлдээсэн Кар[а]чур нь Уйгурын хаант улсыг байгуулахад тэргүүлэн оролцсон гурван аймгийн нэг болох Карлук~Харлуг аймгийн хүн бололтой. Карлук аймаг нь Алтайн нурууны баруун тал Хар эрчис мөрөн, Тарвагтайн нуруу орчмоор VIII–XIII зууныг хүртэл амьдарч байсан нь түүхэн сурвалжуудад тодорхой харагдаж байна.

Мөн Монгол нутгаас олдсон руни бичгийн бага дурсгалуудаас үзэхэд “чур” цолтонгууд (овогтонууд) нь аймаг хооронд цаашлаад улс хооронд мэдээ хүргэх, түгээх үүргийг хүлээсэн өөрөөр хэлбэл тухайн үед элчийн үүргийг гүйцэтгэдэг байсан байх боломжтой байна. Мөн “чур” нь цол гэхээсээ илүүтэй ийм үүрэг хүлээсэн аймгийн доторх нэгэн “овог” байжээ. Мэдээ, хэл хүргэх, түгээх үүрэгтэй “чур” овог нь тухайн үеийн аймаг болгонд байсан бололтой. Өөрөөр хэлбэл Карчур нь бусад аймагт мэдээ, хэл хүргэх үүрэгтэй Карлук аймгийн “чур” овогтон байсан бололтой. Төрийн энэ тогтолцоо Түрэгийн өмнөх үеэс ч улбаатай байхыг үгүйсгэхгүй бөгөөд Уйгурын үед “чур” хэмээх нь нэгэн цол мэт ойлгогдох болсон байх боломжтой.

Бичээст холбогдох тамга нь дүрслэлийн хувьд Уйгурын Яглагар аймгийн тамгатай маш ойролцоо боловч тухайн аймгийн тамга биш байна. Харин тухайн тамга нь Карлук~Харлуг аймгийн тамга бололтой. Тийм учраас Уйгурын хаант улсыг байгуулсан гол гурван аймгийн тамга хоорондоо маш ойролцоо байсан байх боломжтой байна.

Тухайн бичээс нь монгол нутгаас олдсон руни бичгийн бага дурсгалын тоог нэгээр нэмэхээс гадна Баянхонгор аймгийн Галуут сумын нутгаас олдсон Дээд цохиотын бичээстэй яг адилхан байгаа нь түүхийн чухал сурвалж боллоо. Мөн бичээсийн үсэг зурлага, тиг тодорхой бөгөөд руни бичиг хэрэглэгдээд нилээд тогтворжсон үед бичигдсэн байна. Мөн Карчур нь Карлук аймгийн “чур” овогтон (цолтон) бол тухайн бичээс нь Уйгурын хаант улсын үед хамаарах бичгийн дурсгал бололтой.

Товчилсон үгийн жагсаалт:

МХЗБДЖТ — Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь

МНТ — Монгол нууц товчоо

Мо. — Монгол хэл

Тү. — түрэг (турк) хэл

Таних тэмдэгт:

(...) — эшлэл, тайлбар

[...] — зохиогчийн оруулсан нэмэлт тайлбар

Ном зүй**Крилл үсгээр:**

1. Аззаяа Б. Орхон бичгийн дурсгал V (Моюнчурын гэрэлт хөшөө). Улаанбаатар, 2013.
2. Батсүх Д. Билгэ хааны тахилын онгоны балбал чулууны тамга. *Studia Archaeologica*. 2004; XXII, Fasc. 14.
3. Баттулга Ц. Монголын руни бичгийн бага дурсгал (The Small Monuments of Mongolian Runic Inscription) / Монголын Археологийн өв XII. Адмон ХХК. Улаанбаатар, 2020. Х. 364.
4. Баттулга Ц. Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа I (A New Study on Mongolian Runic Inscriptions) // Монголын баруун бүс нутаг дахь руни бичгийн дурсгал. Адмон ХХК. Улаанбаатар, 2022. Х. 216.
5. Баттулга Ц. Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа II (A New Study on Mongolian Runic Inscriptions) // Монголын төв, умард бүс нутаг дахь руни бичгийн дурсгал. Адмон ХХК. Улаанбаатар, 2022. Х. 248.
6. Баттулга Ц. Монголын руни бичгийн дурсгалын шинэ судалгаа III (A New Study on Mongolian Runic Inscriptions) // Монголын зүүн, өмнөд бүс нутаг дахь руни бичгийн дурсгал. Адмон ХХК. Улаанбаатар, 2022. Х.184.
7. Мөнхсайхан С. Монголын нууц товчооны үгийг эшлэн үзүүлсэн толь / Шинжлэх Ухааны Академи. Хэл зохиолын хүрээлэн. Бэмби сан ХХК. Улаанбаатар, 2020. Х. 1522.
8. Мөнхсайхан С. Монголын нууц товчооны тонгоруу толь. Шинжлэх Ухааны Академи. Хэл зохиолын хүрээлэн. Бэмби сан ХХК. Улаанбаатар, 2020. Х.186.
9. Мөнхтулга Р. Таван толгойн бичээс. *Нүүдэлчдийн өв судлал*. XXIII; Fasc. 3:35–53.
10. МХЗБДЖТ [Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь] / Л. Болд, Ц. Өнөрбаян, М. Базаррагчаа нар. Улаанбаатар, 2019. Х. 542.
11. Древнетюркский словарь / В. М. Наделяев, Д. М. Насилов, Э. Р. Тенишев, А. М. Шербак; Академия наук СССР. Институт языкознания. Ленинград: Наука, 1969. С. 676. Текст: непосредственный.
12. Чоймаа Ш. Монголын нууц товчоо. Эртний үг хэллэгийн түгээмэл тайлбартай шинэ хөрвүүлэг. Мөнхийн үсэг ХХК. Улаанбаатар, 2011. Х. 291.
13. Энхтөр А., Далантай С. Шивээт Улааны цогцолбор дурсгалын тухай. *Studia Archaeologica*. 2018; XXXVII, Fasc. 16.

Латин үсгээр:

1. Iskender-Mochiri I. History of Civilizations of Central Asia (Development in contract: from the sixteenth to the mid-nineteenth century). Volume V. Paris: Unesco Publishing, 2003. P. 910.
2. İslam Ansiklopedisi, Türkiye Diyanet Vakfı, Cilt: 24. İstanbul. S. 509; Taşağıl A., Çin Kaynaklarına Göre Eski Türk Boyları (M.Ö III — M.S X. Asır), Atatürk Kültür, Dil ve Tarih Yüksek Kurumu, Türk Tarih Kurumu Yayınları, VII. Dizi, Sayı-206, /2. Baskı/, Ankara, 2013. S. 234.
3. Taşağıl A. Karlukların Coğrafi Dağılımı Üzerine. *Türkiyat Mecmuası*. Cilt: 24 /Bahar/. İstanbul. S. 75–89.

THE DAAHI INSCREPTION

© **Zagarperenley Tumenbayar**

Researcher,
Institute of Language and Literature,
Academy of Sciences of Mongolia
Mongolia, Ulaanbaatar
zagaraa0904@gmail.com

© **Sodnomzhamts D.**

Researcher,
Institute of Archeology,
Academy of Sciences of Mongolia
Mongolia, Ulaanbaatar
sodnomjamts.num@gmail.com

Abstract. We had a reading and examination of a newly discovered runic inscription in the Ulziit sum region of Övörkhongai Province. D. Sodnomjamts, a researcher at the Archaeological Institute of the Mongolian Academy of Sciences, discovered the inscription in August 2022, when he went to the area for field research.


This inscription, consisting of a total of five characters, was written in a single line on a granite-formed rock, and a tamga was depicted next to the inscription. In this research study, besides the meanings of the words in the inscription, how the words are used in other Mongolian runic writing monuments and a brief explanation of the meaning and the seal associated with the inscription are given.

Keywords: The Daakhi Inscription, Turkoloji, Runic Inscription, Linguistics.

Хавсралт



Зураг 1. Өвөрхангай аймаг



Зураг 2. Өлзийт сум



Зураг 3. Өвөрхангай аймгийн Өлзийт сум, Даахь



Зураг 4. Бичээс оршиж буй хадан цохио



Зураг 5. Даахийн бичээс ба тамга

**ЦАХИМ ОРЧНЫ ХАРИЛЦАН ЯРИА БА СЭТГЭЛ ХӨДЛӨЛ
ДИАЛОГИ И ВЫРАЖЕНИЕ ЭМОЦИЙ В ИНТЕРНЕТ-ПРОСТРАНСТВО**

© **Халгар Нармандах**

магистрын оюутан,
Нийгэм, хүмүүнлэгийн ухааны хүрээлэн,
Монгол Улсын Боловсролын Их сургууль
Монгол Улс, Улаанбаатар хот
kh.narmandakh@msue.edu.mn

© **Ширнэн Цолмон**

PhD, багш,
Нийгэм, хүмүүнлэгийн ухааны хүрээлэн,
Монгол Улсын Боловсролын Их сургууль
Монгол Улс, Улаанбаатар хот
tsolmon@msue.edu.mn

Хураангуй. Сүүлийн үед боловсрол, хэлний хөгжлийн судалгаанд орчин үеийн технологи, харилцааны хэрэгслийг ихээхэн ашиглаж байна. Тэр дундаа нийгэм хэл шинжлэлд харилцан яриа, угсаатны арга зүй хэмээн нэрлэгддэг харилцан ярианы дүн шинжилгээ нь хүмүүсийн энгийн харилцааны явцад үүссэн ярианы судалгаа бөгөөд социологич Harvey Sacks (1935–1975)-ийг энэхүү шинжлэх ухааныг үндэслэгч хэмээн үздэг ажээ. Тэгвэл энэхүү харилцан яриа орчин үед буюу цахим ертөнцөд хэрхэн өрнөж, цаашлаад сэтгэл хөдлөлөө хэрхэн илэрхийлж буй нь бидний сонирхлыг татаж түүнд ажиглалт, дүгнэлт хийхээр зорьлоо. Ийнхүү хүмүүс цахим харилцааны явцад сэтгэл хөдлөлийг хэрхэн илэрхийлж буйг задлан шинжлэхдээ дэлхийн алдартай нийгмийн сүлжээний сайтууд болох *Фэйсбүүк*¹ болон *Твиттер* хэрэглэгчдийн зурвасаас баримтаа бүрдүүлсэн болно.

Түлхүүр үг: цахим харилцаа, сэтгэл хөдлөл, сэтгэл хөдлөлийн илэрхийлэл, эможи, Фэйсбүүк, Твиттер.

Харилцан яриа, түүний анализийн арга

Харилцан яриа бол хүний амьдралын чухал, салшгүй хэсэг бөгөөд хүний амьдрал харилцааг бүрдүүлдэг цуврал буюу үргэлжилсэн хэлбэрээр явагддаг нь эргэлзээгүй.

Alotaibi (2013) харилцан яриа нь хувь хүмүүсийн хооронд үр дүнтэй, харилцааг өдөөгч болдгийг онцолсон байдаг. Тийм ч учраас ярианы чадвар нь нийгэмшүүлэх чухал хэмжүүр бөгөөд харилцааны чадвар нь хэлний боловсролын асуудал юм. Жишээлбэл, харилцааны явцад эелдэг байна гэдэг хүмүүсийн хоорондын харилцааны эерэг тал юм.

Аман харилцааны онцлог шинж чанарууд нь цахим орчны яриа, цахим шуудангаар дамжих харилцааны явцад бичвэр хэлбэрээр илрэхэж. Цахим харилцаа нь өнөөгийн өдөр тутмын амьдралын үе шат, харилцан ярианы агуулга, хэлбэрийг агуулсан харилцааны чухал хэлбэр юм. Үүнтэй холбоотойгоор англи хэл нь даяаршлын нөлөөгөөр дэлхий даяар хамгийн өргөн тархсан аман болон аман бус

¹ Принадлежит Meta, которая признана в России запрещенной экстремистской организацией.

харилцаанд хэрэглэгддэг хэлнүүдийн нэг болжээ. Тийм ч учраас хэл шинжлэлийн судалгаанд интернэт болон нийгмийнсүлжээний практик нь цахим яриа гэгддэг хэлний шинэ төрлүүд гарч ирэхэд хүргэдэг. Цахим яриа ихэвчлэн динамик байдлаар явагддаг тул хүмүүсийн бичих аргад голчлон илэрдэг нь байгалиас өгөгдсөн гэмээр. Интернэт, цахим харилцааны хурдацтай өсөлт нь харилцааны олон талын хэлбэрүүдийн эрэлтийг нэмэгдүүлсэн [1, с. 135]. Сүүлийн жилүүдэд цахим харилцааны хэрэглэгчдийн хэлний хэрэглээг судлах сонирхол нэмэгдэж байна [7, 8], [20, с. 45–68], [29], [23, с. 345–366], [27, с. 98–103]. Хэлний гол зорилго нь харилцаа, мэдээлэл дамжуулах, түгээх явдал юм. So (2009)-ийн хэлснээр цахим харилцаа үүсэх үед харилцагчидтөрөл бүрийн тэмдэг, дохио зангаа, дүрслэл, дуу-хоолойн бичлэг, болон бусад паралингвистик шинжтэй зүйлс ашиглаж мэдээллийг амаар болон аман бус хэлбэрээр илэрхийлж байна. Ийм аргууд нь харилцагчдадзурвас (мессеж)-ын утгыг илүү сайн хүлээн авч, ойлгоход тусалдаг. Хүмүүс ихэвчлэн зорилго, хам сэдэв болон хэлний бусад хүчин зүйлээс хамааран хэлний янз бүрийн хувилбаруудыг ашигладаг.

Ярианы хэлийг судлах хэд хэдэн хэл шинжлэлийн арга байдаг (Eggins & Slade 1997). Эдгээр нь гүн ухаан, угсаатны зүй, нийгэм-хэл шинжлэл, сэтгэл судлал зэрэг бусад салбаруудад ч хамаардаг байна. Харилцан яриаг судлах аргуудыг авч үзье.

1. Логик-философи: а. Ярианы үйлдлийн онол
б. Прагматик
2. Угсаатны (Этно)-аргазүй: Харилцан ярианы анализ
3. Нийгэмхэл шинжлэл: а. Харилцан ярианы этнографи
б. Харилцааны нийгэмхэл шинжлэл
4. Бүтэц-үүрэг: Бөрмингхамын дэг (Birmingham School)

Tang, New (2017) нар орчин үеийн технологи, харилцааны хэрэгслийг ашиглах нь хэл шинжлэлийн судалгаа хийх боломжийг нээж өгч, интернэт хэл шинжлэл, цахим орчны яриа, хэлний хөгжлийн талаар шинэ хувилбарууд, харилцааны шинэлэг аргуудаар судалгаа хийх боломжийг ч олгодог хэмээн дурдсан нь дээрх ангилалтай дүйнэ.

Нийгмийн сүлжээний цахим сайтууд боловсролын байгууллагын анхаарлыг татах болсон. Сурагчид болоод бодлого боловсруулагчид тэдгээрийг хэлний боловсролын үр дүнтэй хэрэгсэл ч гэж үзэх тохиолдол байна. Эдгээр технологийн хөгжил, хэрэглээ, тухайлбал, Facebook, Twitter, YouTube, MySpace гэх мэт ниймийн сүлжээний сайтууд сүүлийн үед түгээмэл болж, өсөн нэмэгдэж байна [1, с. 135]. Шинэ аппликейшнүүд нь компьютерт суурилсан виртуалорчинд нийгмийн мэдээллийн сүлжээгээр дамжуулан хялбархан харилцах боломжийг хэрэглэгчдэдээ олгож байгаа нь бидний судалгаа шинэлэг, орчин үетэйгээ хөл нийлүүлэн алхаж буйн шинэ биз ээ.

Нийгмийн сүлжээний сайт гэдэг нь виртуал ертөнцөд хүмүүс хоорондоо хялбархан аргаар харилцаж, санал бодлоо хуваалцах сонирхолтой холболтоор хангадаг платформ юм. Тухайлбал, Фэйсбүүк бол нийгмийн сүлжээний сайтын нэг жишээ. Түүний гол онцлог нь "нүүр хуудас", "мэдээлэл", "блог", "найзууд", "дуртай", "дургүй", "сэтгэгдэл", "зурвас илгээх", "зураг хуваалцах", "холбоосууд", "видео" [31] юм гэсэн нь бусдаасаа дээр дурдсан зүйлсээр ялгарч, улмаар хамгийн олон хүн хэрэглэдэг НСС болтлоо өргөжсөнийг илтгэж буй хэрэг буй заа. Энэ нь

хэрэглэгчдэд харилцааны янз бүрийн хэлбэрийг ашиглан хоорондоо ярилцах, дэлхий даяар шинэ нөхөрлөлийн холбоо бий болгох боломжийг олгодог болох нь дээрх тодорхойлолтыг баталж буй хэрэг юм.

Харилцан ярианы анализ гэдэг нь бодит орчинд ярих, бичих чадварын хоорондын хамаарлыг судлахыг хэлнэ. Энэ нь нийгмийн харилцааг судалж дүн шинжилгээ хийхэд онцгой, үр дүнтэй арга болж хөгжиж байна (Paulus et al, 2018).

Харилцан ярианы анализ нь найз нөхдийн дунд төдийгүй цахим орчинд аяндаа өрнөдөг нийгмийн харилцан ярианд анхаарлаа хандуулдаг бөгөөд энэ бүтэц нь хэлэлцүүлэг, яриа өрнүүлэх, ээлжлэн хариулах, засаж залруулах хэрэгцээ зэргээр тодорхойлогддог.

Rose, Spinks, Canhoto [25] нар харилцан ярианы онцлог шинж чанаруудад дараах зүйлс хамаарна хэмээжээ. Үүнд:

1. Аман яриа болон бүлгийн харилцаанд анхаарлаа хандуулах
2. Аяндаа бий болж буй хэлний нарийвчилсан хувилбарыг задлан шинжлэх
3. Харилцагчийн илэрхийлэх гэсэн өнгө аяс, санааг ойлгох нь тухайн бүс нутгийн онцлог, түүнээс үүдэн гарах харилцан ярианы нөхцөл байдлаас шалтгаална
4. Макро-нийгмийн үзэгдлүүд нь харилцан ярианы явцад харилцагчдын аль алинд хамааралтай үед л баримт болгон ашиглагдана.

Харилцан ярианы анализ нь хэл шинжлэлийн салбар судлагдахуун бөгөөд нийгмийн үзэгдэл судлал буюу угсаатны аргазүйгээс үндэстэй бөгөөд логик-аналитик болон герменевтик-диалектик хэтийн төлөвийг хослуулсан [13, с. 224–272] [17]. Roger, Bull (1989) нар харилцан ярианы явцыг судлах арга гэж тодорхойлсон байна. Үүний нэгэн адил ten Have (1999) харилцан ярианы анализийг харилцагчид нийгмийн харилцааны дэг журмыг сахиулах арга замуудын тайлбар гэж тодорхойлсон нь цахим харилцааны явцад бичиг үсгийн замбараагүй хэрэглээг хянаж, цахим орчинд зөв зохистой байхтай холбоотой дүгнэлт гэж ойлгож болохоор байна.

Hopper, Koch, Mandelbaum (1986) нарын хэлснээр харилцан ярианы анализ нь түүний үйл ажиллагааны бүтэц, хувь хүмүүсийн харилцан ярианы практикийг ойлгоход ашиглагддаг. Харилцан ярианы анализ нь хүний хэлсэн үг хэллэгээс илүү эргэн хариу өгөх үйлдэлд дүн шинжилгээ хийх болон өгөгдлийг зохицуулах, асуудлуудыг өөрчлөхөд тусалдаг [13, с. 224–272] [17].

Seliger, Shohamy's (1989) чанарын өгөгдлийг баталгаажуулах гурван элементийн шалгуурыг гаргажээ. Үүнд, (а) өгөгдлийг шууд нэвтрэн орж олж авах боломжтой, (б) цуглуулсан жишээгээ баримт болгон баталгаажуулж судалгааг бодитой болгох (в) өгөгдлийн төлөөлөх чадвар зэрэг нь бидний тулгуурласан гол чиг юм.

Сэтгэл хөдлөл, түүнийг цахим орчинд илэрхийлэх нь

